

ТӨСЛИЙН НЭГЖИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН МЭРГЭЖИЛТНИЙ АЖЛЫН БАЙРЫГ ДАХИН ЗАРЛАЖ БАЙНА

Монгол Улсын Засгийн газраас Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ны дэмжлэгтэйгээр “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Төслийг хэрэгжүүлэгч байгууллага нь Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам (ЗТХЯ) юм. Уг төслийн хүрээнд **Нийгмийн хамгааллын чиглэлээр мэргэшсэн ажилтныг Төсөл хэрэгжүүлэгч нэгж (ТХН)-ийн орон тооны ажилтнаар авч ажиллуулахаар ЗТХЯ-наас сонгон шалгаруулалт зарлаж байна.**

Зорилго

Нийгмийн хамгааллын мэргэжилтэн нь Байгаль орчны нөлөөллийн үндэсний үнэлгээ, Олон улсын байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, Оролцогч талуудын хамтын ажиллагаа, оролцооны төлөвлөгөө, Байгаль орчин, нийгмийн удирдлага, хяналтын төлөвлөгөө, Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Газар чөлөөлөх, өрхийн амьжиргааг сайжруулах журам болон бусад холбогдох үйл ажиллагааны төлөвлөгөө – нийтэд нь “Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний багц”-ын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах, тайлагнах үүрэгтэй. Уг мэргэжилтэн нь нийгмийн нөлөөлөлтэй холбоотой асуудлуудыг тодорхойлж, гүйцэтгэгч эсхүл ЗТХЯ-наас авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд шаардлагатай мэдээлэл, зөвлөмжийг өгч хамтарч ажиллана.

Нийгмийн хамгааллын мэргэжилтэн нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлого болон нийгмийн нөлөөллийн үнэлгээ, удирдлага, газар чөлөөлөлт, хөдөлмөр эрхлэлтийн стандарт, оролцогч талуудын хамтын ажиллагаа, оролцоотой холбоотой бусад холбогдох шаардлагуудын хүрээнд ажиллах ба орон нутгийн иргэд олон нийтэд үзүүлэх аливаа нөлөөллийг үр дүнтэй удирдан зохион байгуулж ажиллана. Мэргэжилтэн нь барилгын ажлын гүйцэтгэлийн явцад бүх оролцогч талуудыг нийгмийн өндөр шаардлага стандартуудыг хангаж ажиллах нөхцөл бололцоогоор хангах зорилгоор ЗТХЯ-ны нэрийн өмнөөс нийгмийн шинжтэй гэрээ хэлцэлтэй холбоотой аливаа асуудлыг хариуцаж ажиллана.

ТАВИГДАХ ШААРДЛАГА

Боловсрол: Нийгмийн ухаан эсхүл бусад холбогдох чиглэлээр бакалавр, магистрын зэрэгтэй байх

Туршлага: Нийгмийн хамгаалал, оролцогч талуудын хамтын ажиллагаа, оролцооны чиглэлээр мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, Монгол Улсын нийгэм, хөдөлмөрийн тухай холбогдох хууль тогтоомж, олон улсын туршлагыг дагаж мөрдөх.

Дараах чиглэлээр ажилласан туршлагатай бол давуу тал болно. Үүнд:

1. Нийгмийн гүйцэтгэлийн удирдлага, оролцогч талуудын хамтын ажиллагаа, оролцоо, олон нийтийн оролцоо, зөвлөх үйл ажиллагааны чиглэлээр төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж эсхүл олон улсын санхүүгийн байгууллагад ажилласан туршлагатай байх;
2. Олон улсын санхүүгийн байгууллагын нийгмийн хамгааллын шаардлагуудын талаар мэдлэгтэй байх;



UB - DARKHAN ROAD PROJECT, OPID 50766



3. Жендэрийн асуудал, үнэлгээний чиглэлээр ажилласан туршлагатай байх;
4. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, тухайлбал, Хөдөлмөрийн тухай хуулийн талаар мэдлэгтэй байх.

Хэрэв та дээрх шаардлагуудыг хангаж байгаа бол өөрийн ур чадвар/туршлагын талаар дурдсан дэлгэрэнгүй CV, тухайн албан тушаалд тохирч буй талаарх захидал, диплом, гэрчилгээний хуулбар болон сүүлийн хоёр ажил олгогчийн тодорхойлолтыг бүрдүүлж, **2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 16:00 цагаас өмнө** ирүүлнэ үү. **Зөвхөн шаардлага хангасан нэр дэвшигчидтэй эргэж холбогдох болно. Нийгмийн хамгааллын мэргэжилтний** сонгон шалгаруулалтад оролцогч нь материалаа доорх хаягаар өөрийн биеэр авч ирнэ. Ирүүлсэн материалыг оролцогчид буцаан олгохгүйг анхаарна уу. Бүрэн бус материалыг хүлээж авахгүй. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл бидэнтэй холбогдоно уу.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар 14251, Чингисийн өргөн чөлөө-11, Засгийн газрын 13-р байр, Зам, тээврийн хөгжлийн яам, 307 тоот өрөө; **Холбоо барих:** Э.Бадамсүрэн Утас: +(976) 51-263179.